

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Монгол Ус ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: САГ-2019/112/СТА-ТӨҮГ

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан.....	4
	2.1. Оршил.....	4
	2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
	2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
	2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
	2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
	2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
	2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
	2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
	2.8.1. Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл	8
	2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал.....	8
	2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	8
	2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
	2.10. Үйл ажиллагааны орлого, зарлагын гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
	2.11. Шилэн дансны мэдээлэл	9
	2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
	2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3	Менежментийн захидал.....	10
	3.1 НББ-ийн бодлогын бичиг баримттай холбоотой асуудал.....	10
	3.2 Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал	11
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12
	4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	12
	4.2 Аудит хийсэн санхүүгийн орлогын дэлгэрэнгүй тайлан	13
	4.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	14
	4.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	15
	4.5 Аудит хийсэн 2018 оны зорилтот түвшин, гүйцэтгэл	16
5	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	17

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2018.03.15 № 06/492
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Монгол Ус” ТӨААТҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Монгол Ус” ТӨААТҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Монгол Ус” ТӨААТҮГ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

“Монгол Ус” ТӨААТҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Монгол Ус ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн аудитын дүн, дүгнэлтийг Монгол Ус ТӨААТҮГ-ын захирал Г.Билэгсайхан танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1,18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монгол Ус ТӨААТҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Монгол Ус ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

Монгол Ус ТӨААТҮГ-ын удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 02 дугаар сарын 25-наас 03 дугаар сарын 05-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 03 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Монгол Ус ТӨААТҮГ-ын захиралд хүргүүлэхээр төлөвлөн, Эвиденсе Аудит ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Монгол Ус ТӨААТҮГ 2018 оны санхүүгийн тайланг тодруулгын хамт Эвиденсе Аудит ХХК-д 2019 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 1/24 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, СТОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Монгол Ус ТӨААТҮГ-ын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго: Монгол Ус ТӨААТҮГ нь Монгол улсын хэмжээнд усны салбарын бодлогыг тууштай хэрэгжүүлэгч, хөгжлийг түргэтгэгч, дэмжин туслагч, түншлэгч хамтран ажиллагч байгууллага байна. Үйлдвэрийн газрын үндсэн зорилт нь Монгол улсын нутаг дэвсгэрт усны нөөцийн менежментийг хийж, төрийн эзэмшлийн болон төсвийн хөрөнгөөр баригдсан усны барилга байгууламж түүний дотор толгойн барилга байгууламжуудийн ашиглалт, засвар үйлчилгээг хариуцан, усны үндсэн эх үүсвэрийн усны барилга, байгууламжийг шинээр байгуулах, гадаад дотоодын төсөлд менежмент, хяналт шинжилгээ хийж, найдвартай үйл ажиллагаа явуулахад оршино.

Үйл ажиллагааны чиглэл:

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 280 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар Монгол Ус ТӨААТҮГ-ын бүтцийг 37 орон тоотойгоор баталсан байна.

Монгол Ус ТӨААТҮГ нь Монгол улсын Усны тухай хуульд нийцүүлэн усны нөөцийн менежментийг хийх, Төрийн эзэмшлийн болон төсвийн хөрөнгөөр баригдсан усны барилга байгууламж түүний дотор усны толгойн барилга байгууламжийн ашиглалт засвар үйлчилгээг хариуцан улсын хэмжээнд усны нөөцөд эрэл хайгуул, судалгаа хийх, усны нөөцийн ордуудыг боломжит нөөцийн хэмжээнд ашиглуулах, зөвшөөрөл өгч ус ашигласны төлбөрийг улсын төсөвт төвлөрүүлдэг эрх бүхий төрийн эзэмшлийн цорын ганц корпораци юм.

- Хоногт 100 шоо метрээс их ус ашиглах, эрчим хүч, усалгаатай газар тариалан, усан тээврийн зориулалтаар ус ашиглуулах дүгнэлт;
- Хоногт 50 шоо метрээс их хаягдал ус гаргадаг ус бохирдуулагчид хаягдал ус зайлуулах тухай дүгнэлт;
- Голын гольдролыг өөрчлөх, урсацад тохируулга хийх, усны сан бүхий газрын ашиглалтын төсөлд мэргэжлийн дүгнэлт гаргах;
- Усны барилга байгууламж барих, ашиглах, судалгаа хийх, дүгнэлт гаргах;
- Хадлан, бэлчээр, тариаланг усжуулах инженерийн хийцтэй усалалтын систем барих ажлын хайгуул, судалгаа, зураг төсөлд мэргэжлийн дүгнэлт гаргах;

- Хүн амын төвлөрсөн ус хангамж, ариутгах татуурга, усны нөөцөд тохируулга хийх, хуваарилах зориулалт бүхий барилга байгууламжийн ашиглалт, засвар үйлчилгээг сайжруулах арга хэмжээ авах;
- Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын төлбөрийн хувь хэмжээтогтоосон хүснэгтийн 10 дахь хэсэгт заасан үйл ажиллагаа буюу ашиг олох зорилгоор ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага, иргэний ашигласан усны төлбөрийг тооцох

Усны улсын төсвийн хөрөнгөөр газрын доорх усны эрэл хайгуул, судалгаа явуулж нөөц нь тогтоогдсон ордуудын нөхөн төлбөрийг тооцож, төлбөрийг улсын төсөвт төвлөрүүлэх, усны нөөцийн ордуудыг боломжит нөөцийн хэмжээнд ашиглуулах, ус хангагчийн үүрэг гүйцэтгэх зэрэг чиг үүргүүд багтаж байгаа болно.

Монгол Ус ТӨААТҮГ-ын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан.

Монгол Ус ТӨААТҮГ-ын удирдлага Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Компанийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Монгол Ус ТӨААТҮГ-ын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2013 онд боловсруулсан боловч, холбогдох стандарт, хууль тогтоомж, Сангийн яамнаас батлан гаргасан журам, нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлтэй нийцээгүй байна.

Монгол Ус ТӨААТҮГ-ын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд “бага” буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитын томилогдсон баг гүйцэтгэлээ.

Монгол Ус ТӨААТҮГ-ын санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Даймонд” програм хангамж ашигладаг байна.

Монгол Ус ТӨААТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “Үр нөлөөтэй” гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Монгол Ус ТӨААТҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, тодруулгатай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 4 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 3 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт ашгийн үзүүлэлтийг сонгов.

Санхүүгийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт ашгийг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь уг байгууллага нь ТӨААТҮГ бөгөөд олон тооны бага үнийн дүнтэй шинжилгээний борлуулалтууд хийгддэгтэй холбоотой.

Монгол Ус ТӨААТҮГ-ын 2018 оны орлогын д элгэрэнгүй тайлангийн нийт ашиг нь 446.7 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 4.5 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь тухайн байгууллага аудитын чиглэлүүдэд үзүүлж болзошгүй эрсдлийн “Дунд” үнэлгээг харгалзан үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 3 чиглэлээр аудитын 3 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд алдаа зөрчил илрээгүй бөгөөд 2 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

2.8.1. Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах асуудлыг залруудан санхүүгийн тайланд тусгаж, Монгол Ус ТӨААТҮГ-ын удирдлагаар зөвшөөрүүлэн баталгаажуулав. Үүнд:

- Салбарын 90 жилийн ойн арга хэмжээг тэмдэглэхээр бусад байгууллагаас авсан 142.5 сая төгрөгийн хандив тусламжийг орлогоор бүртгэсэн.
- Салбарын 90 жилийн ойн арга хэмжээг тэмдэглэхэд гарсан 133.9 сая төгрөгийн зардлыг татвар ногдох зардлаас хасагдах зардлаар бүртгэсэн болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

/мянган төгрөгөөр/

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2	0.00	
	Дүн	2	0.00	

2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Асуудал 1: Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаа

Салбарын 90 жилийн ойн арга хэмжээг тэмдэглэхээр бусад байгууллагаас авсан 142.5 сая төгрөгийг хандив тусламжийг орлогоор бүртгэсэн.

Шийдэл:

Алдааг өглөгийн дансанд төвлөрүүлж залруулсан.

Асуудал 2: Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаа

Салбарын 90 жилийн ойн арга хэмжээг тэмдэглэхэд гарсан 133.9 сая төгрөгийн зардлыг татвар ногдох зардлаас хасагдах зардлаар бүртгэсэн.

Шийдэл:

Алдааг өглөгийн дансыг бууруулж залруулсан.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Монгол Ус ТӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар НӨАТ-ын асуудлыг нарийвчлан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

2.10. Үйл ажиллагааны орлого, зарлагын гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 564 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар Монгол Ус ТӨААТҮГ-ын 2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний орлогыг 773.0 сая төгрөгөөр, зардлыг 677.0 сая төгрөгөөр баталсан байна.

Тайлант жилд үндсэн үйл ажиллагаанаас 694.9 сая төгрөг, хүүгийн болон бусад орлогоос 5.7 сая төгрөг нийт 700.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж зорилтот түвшингийн орлогын төлөвлөгөөг 90.6 хувиар буюу 72.3 сая төгрөгөөр дутуу биелүүлсэн байна. Тайлант жилд төлөвлөсөн зардлыг зорилтот түвшин баталсан хэмжээнд зарцуулсан боловч 2015 онд үүссэн Оюу толгой ХХК-иас авах 173.8 сая төгрөгийн авлага нь шүүхийн шийдвэрээр хүчингүй болсон. Иймд тайлант жилд 107.4 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Монгол Ус ТӨААТҮГ-ын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Монгол Ус ТӨААТҮГ нь Шилэн дансны тухай хуульд заасны дагуу хуульд заасан хугацаанд жил, улирал, сар, тухай бүр оруулах мэдээллийг бүрэн оруулсан байна.

Шилэн дансанд:

- Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгнөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр
- Гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн нэгтгэсэн мэдээллийг
- Зорилтот түвшний гүйцэтгэлийг
- Хөрөнгө оруулалт
- Худалдан авалт
- Хагас жилийн санхүүгийн тайланг тус тус байршуулсан байна.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 4 зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Монгол Ус ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Монгол Ус ТӨААТҮГ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Монгол Ус ТӨААТҮГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 НББ-ийн бодлогын бичиг баримттай холбоотой асуудал

3.1.1. Илрүүлэлт:

Тус байгууллагын НБББББ-ийг 2013 онд боловсруулсан боловч байгууллагын үйл ажиллагааны онцлог, чиглэл, нягтлан бодох бүртгэлтэй нийцээгүй байна.

3.1.2 Эрсдэл:

НБББББ нь хангалтгүй байснаар СТОУС-ын дагуу нягтлан бодох бүртгэлийг хөтлөхөд хүндрэл гарах, СТОУС-ыг дутуу мөрдөх, буруу хэрэглэх, бүртгэлийн үйл ажиллагаа нь ажилтнуудын мэргэжлийн шийдлийн хүрээнд явагдахад сөрөг нөлөөллүүд гарч болно.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

СТОУС болон холбогдох хууль журмын шаардлагад нийцсэн НБББББ-ийг боловсруулан СТОУС-ын шинэчлэлт өөрчлөлтийг тухай бүр нэмэлт өөрчлөлт болгон тусгах нь зүйтэй.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

НБББББ-г шинэчлэн боловсруулж ажиллана. Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 06 дугаар сарын 01-ний дотор ирүүлнэ.

3.2 Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Бэлэн мөнгөний нярав кассын бүртгэлийг гараар хөтөлдөггүй, өдөр бүр үлдэгдлээ бодитоор гаргахгүй байгаа нь Монгол Улсын Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан "Анхан шатны бүртгэлийн маягт зааврыг мөрдөж ажиллах" журамд нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх болон хөрөнгө шамшигдуулах, мөнгөн хөрөнгийн хяналт сулрах.

3.2.3 Зөвлөмж:

Заавар журмыг мөрдөж ажиллах, өдөр бүр гараар бичиж кассын дэвтэр хөтлөх.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2017 оны 12 сарын 31	2018 оны 12 сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	114,423,850.85	842,483,104.08
1.1.2	Дансны авлага	186,070,308.30	6,314,900.00
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	3,700,320.85	10,818,439.24
1.1.6	Бараа материал	2,222,229.21	8,421,284.64
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	1,662,008.71	1,902,017.35
	Эргэлтийн хөрөнгийн дүн	308,078,717.92	869,939,745.31
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,505,957,358.44	1,442,185,074.12
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,505,957,358.44	1,442,185,074.12
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,814,036,076.36	2,312,124,819.43
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	20,000.00	8,518,092.51
2.1.1.2	Цалингийн өглөг	6,799,116.50	6,861,578.72
2.1.1.3	Татварын өр	3,122,778.45	496,000.00
2.1.1.4	НДШ–ийн өглөг	95,497.05	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	-	602,070,378.00
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	10,037,392.00	617,946,049.23
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
	Урт хугацаат өр төлбөрийн дүн		
2.2	Өр төлбөрийн нийт дүн	10,037,392.00	617,946,049.23
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	1,674,923,107.29	1,674,923,107.29
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг		
2.3.9	Хуримтлагдсан ашиг	129,075,576.10	19,255,662.92
2.3.11	Эздийн өмчийн дүн	1,803,998,683.39	1,694,178,770.21
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,814,036,075.39	2,312,124,819.44

4.2 Аудит хийсэн санхүүгийн орлогын дэлгэрэнгүй тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	597,359,964.74	694,970,942.08
2	Борлуулалтын өртөг	193,779,812.44	253,896,109.94
3	Нийт ашиг(алдагдал)	403,580,152.30	441,074,832.14
4	Түрээсийн орлого		
5	Хүүгийн орлого	1,325,715.38	5,423,135.49
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого		250,000.00
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	377,685,641.45	380,237,089.73
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	129,000.00	173,804,108.30
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-433,441.35	-130,810.00
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		3,317.22
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	26,657,784.88	-107,420,723.18
19	Орлогын татварын зардал	2,665,778.49	
20	Татварын дараах ашиг (алдагдал)	23,992,006.39	-107,420,723.18
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	23,992,006.39	-107,420,723.18
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн		
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

4.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2017 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	1,674,923,107.29		149,495,929.70	1,824,419,036.99
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				
3	Залруулсан үлдэгдэл				
4	Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)			23,992,006.39	23,992,006.39
6	Өмчид гарсан өөрчлөлт				
7	Зарласан ногдол ашиг			-44,412,360.00	-44,412,360.00
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				
9	2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,674,923,107.29		129,075,576.09	1,803,998,683.38
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				
11	Залруулсан үлдэгдэл				
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			-107,420,723.18	-107,420,723.18
13	Бусад дэлгэрэнгүй орлого				
14	Өмчид гарсан өөрчлөлт				
15	Зарласан ногдол ашиг			-2,399,190.00	-2,399,190.00
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				
17	2018 сарын 12-р сарын31 -ний үлдэгдэл	1,674,923,107.29		19,255,662.91	1,694,178,770.20

4.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	579,009,708.93	1,470,556,812.82
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	579,009,708.93	1,470,556,812.82
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	484,768,462.44	692,221,247.02
1.2.1	Ажиллагчдад төлсөн	327,615,883.42	337,387,841.44
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	64,940,443.46	76,990,210.21
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	32,183,346.54	31,322,741.52
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	794,984.00	564,100.00
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	13,959,002.73	20,980,209.11
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	44,104,759.46	41,869,312.51
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	213,840.00	213,840.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	956,202.83	182,892,992.23
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	94,241,246.49	778,335,565.80
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,325,715.38	5,423,135.49
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	1,325,715.38	5,423,135.49
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)		53,303,658.27
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		53,303,658.27
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,325,715.38	-47,880,522.78
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		3,400.21
3.1.4	Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг		3,400.21
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	44,412,360.00	2,399,190.00
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
3.2.4	Төлсөн ногдол ашиг	44,412,360.00	2,399,190.00
3.2.5			
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-44,412,360.00	-2,395,789.79
4	Валютын ханшийн зөрүү		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	51,154,601.87	728,059,253.23
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	63,269,248.98	114,423,850.85
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	114,423,850.85	842,483,104.08

4.5 Аудит хийсэн 2018 оны зорилтот түвшин, гүйцэтгэл

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Д/д	Үзүүлэлтүүд	2018 оны		Зөрүү	Хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Нийт орлого	773,000.00	700,644.40	-72,355.60	90.64%
	Үүнээс цэвэр борлуулалт	773,000.00	694,970.95	-78,029.05	89.91%
2	Нийт зардал	677,004.50	808,068.20	131,063.70	119.36%
	Удирдлага/бор-ын зардал	377,854.20	380,236.40	2,382.20	100.63%
3	Татварын өмнөх ашиг/алдагдал	95,995.50	-107,423.80	-203,419.30	-111.91%
	Орлогын татварын зардал	9,599.55	-	-9,599.55	0.00%
4	Цэвэр ашиг /-/	86,395.95	-107,420.80	-193,816.75	-124.34%
6	Төсвийн төлбөрт	100,563.34	114,820.10	12,165.86	111.85%
	а/Аж ахуйн нэгжийн орлогын албан /тат	9,599.50	2,592.80	-7,006.70	27.01%
	б/НДШ, ЭМД	46,253.40	77,008.90	30,755.50	166.49%
	в/ХХОАТ	27,431.25	28,617.30	1,186.05	104.32%
	д/Ногдол ашиг	17,279.19	2,399.20	-14,879.99	13.88%
	е/Бусад	2090.9	4,201.90	2,111.00	200.96%
7	Ажиллагсдын тоо	38	33	-5.00	86.84%
8	Нийт цалингийн сан	364,200.00	333,615.40	-30,584.60	91.60%
9	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	0.88	1.15	0.28	131.69%
10	Нийт авлага		17,133.30	17,133.30	
11	Нийт өглөг		617,946.00	617,946.00	
12	Хөрөнгө оруулалт	53,362.40	53,303.60	-58.80	99.89%

5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2019.03.05	Аудитын нэр:	Монгол Ус ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, тодруулагад хийсэн аудитын тайлан	Аудитын код:	САГ-2019/112/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр:	МОНГОЛ УС ТӨААТҮГ			Мянган төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5
1	Тус байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2013 онд боловсруулсан боловч байгууллагын үйл ажиллагааны чиглэл нягтлан бодох бүртгэлтэй нийцээгүй байна.		Зөвлөмж	Нягтлан бодогч	М.Энхтүвшин
2	Бэлэн мөнгөний няравын кассын бүртгэл хөтлөлт сул, өдөр бүр кассын дэвтэр хөтөлж үлдэгдлээ бодитоор гаргахгүй байгаа нь Монгол Улсын Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан "Анхан шатны бүртгэлийн маягт зааврыг мөрдөж ажиллах" журамд нийцэхгүй байна.		Зөвлөмж	Нягтлан бодогч	М.Энхтүвшин

